

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



Үүсгэн байгуулагчийн сургаал

Өвчинд нийцүүлэн эмийг олгох нь

“Ямар “Хэрвээ номыг сонсох завшаан тохиосон хүмүүн байх аваас нэг нь ч болов Бурханы хутаг олохгүй байх явдал үгүй болой.” хэмээн Бурхан Багшийн амлалт өгсөн Цагаан Лянхуа Судар бол ямар ч хүнийг аврах жинхэнэ сургаал юм. Гэвч өвчний төрөл болон илааршилтын байдлаас хамаараад эмчийн бичиж өгөх эм бүр ялгаатай байдаг шиг жинхэнэ сургаалыг ч мөн адил тухайн хүн, тухайн зовлон шаналалаас нь хамаараад хамгийн тохиромжтой хэлбэрээр, бодитойгоор айлдахгүй юм бол жинхэнээсээ бусдыг аварч эс чадна.

Тухайн асуудал, тухайн хүнд тохирсон арга нь Уран арга юм.

Зөвхөн үнэн сургаалыг айлдчихаад, хэрэв

ойлгохгүй байвал таны түвшин хэтэрхий доогуур байна гэх зэргээр хэлэх юм бол энэ нь нигүүлсэнгүй сэтгэл хангалтгүй байна гэсэн үг юм.

Энэ хүнийг яаж ийж байгаад аврахсан гэж чин сэтгэлээсээ бодох юм бол өөрийнхөө туршлага, мэдлэг зэрэг бүхий л хүч чадлаа дайчлан шавхах нь лавтай.

Тэрхүү энэрэл нигүүлслийн далай их сэтгэл байхад ямар ч хүчтэй үг хэлсэн, нөгөө хүн тань эсэргүүцэж, таныг буруутгахгүй. Мөн эелдэг зөөлөн үгээр харилцагч хүнээ аргадан эрхлүүлж, мунхруулах явдал огтоос байхгүй болно.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, Х.66-67

Living the Lotus
Vol. 168 (2019,09)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Коочироо

Орчуулсан: Ж.Сэлэнгэ

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Турван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцагая гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



“Ялгаа”-тай болохоороо л

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Бүхнийг энэрч хайрлах сэтгэл

Кино Цүраюкигийн “Эрт эдүгээгийн Япон дууллын цуглуулга”-т байдаг өөрийнх нь хайрын тухай дуунуудын нэгэнд дараах дуу байдаг.

“Орчлонгийн жам
Чухам ийм ажгуу
Үлээх салхин адил
Үзэж хараагүй хүмүүнд ч
Янагийн сэтгэл төрмүй
(Салхилаад өнгөрөх аясын салхи шиг
Царайг нь ч хараагүй нэгнийг хайрлах нь
Хорвоо ертөнцийн жам юмуу даа.)”

Үүнийг хайр дурлалын тухай дуу гэж ойлгож болох ч нэгэн хүний ярьснаар бол энэхүү дуу нь бидний огт анзаараагүй нэгэн “Жинхэнэ үнэн”-ийг дуулдаг гэнэ. Тэрхүү “Жинхэнэ үнэн” гэдэг нь хүн бүгд сэтгэлийнхээ гүнд энэ ертөнцөд орших бүхнийг хайрлан, нигүүлсдэг гэсэн үг юм.

Гэвч бодит байдал дээр тийм гэхийн аргагүй нөхцөл байдал хаа сайгүй бий. Үзэл бодол болон аливааг харах өнцгийн ялгаа нь түүний шалтгаан бөгөөд бусадтай маргалдах, хоорондоо тэмцэлдэх, хамтын харилцаагаа таслах, улс орнууд хоорондоо дайтах зэргээр... Хамгийн харамсалтай нь шашин хоорондын маргалдаан ч бодит асуудал болон оршсоор байна. Олонх нь бусдаас ялгарах ялгаагаа хүлээн зөвшөөрч чадахгүйгээсээ болж зовж шаналж, ямар ч үр ашиггүй дайн хүртэл хийж байна.

Тэдгээрийн дотроос бидэнд хамгийн амар хийж чадах зүйл бол бусдаас ялгарах онцлог байдлаа ялгаа хэмээн хүлээн зөвшөөрөх явдал бөгөөд тэгэхийн тулд юун түрүүнд “Миний цээжин дотор энэ ертөнцийн бүхий л зүйлийг энэрч хайрлах сэтгэл, нигүүлсэх зүрх сэтгэл бий” хэмээн мэдрэх явдал юм. Тэгэх юм бол бүгд өөр хоорондоо ялгаатай байхын давуу тал, үнэ цэнэ харагдаж ирэх болно.



“Ялгаа”-тай байхын утга учир ба үнэ цэнэ

Бид бүгдтүс бүртээ өөр өөр дотоод ба гадаад шалтгааны үрээр хорвоод мэндэлсэн. Мөн төрсөн хойноо ч бүгд өөр өөр гадаад шалтгаантай учирч “Би” гэсэн онцлог чанар бүхий хувь хүн болдог.

Тиймээс арьсны өнгө, гадаад төрхөөс эхлээд үзэл бодол болон юмсыг харах өнцөг нь ялгаатай байх нь мэдээжийн хэрэг байтал, тэрхүү ялгаагаа шалтгаан болгон хоорондоо зөрчилдөх, үгүйсгэх зэрэг нь өөрийнхөө онцлогийг хүлээн зөвшөөрөхгүй байгаатай адил юм.

Шашны ертөнцөд ч гэсэн хүн бүр өөр өөрийн учрал шалтгаанаас хамааран аврагдах зам нь ялгаатай байх нь мэдээжийн хэрэг ба Христийн шашны номлолоор аврагдах нэгэн байхад, Исламын шашны номлол ба Буддын шашны номлолоор ч аврагдах нь бий. Өөрөөр хэлбэл амар тайвныг эрэлхийлэгч хүнд энэ хорвоод итгэж сүсэглэх ном маш олон бий гэсэн үг. Энэ дэлхийд амьдарч буй бүх хүнд амар амгаланг өгөхийн тулд шашин, шашны бүлгүүд өөрсдийн гэсэн онцлогоо нээн илрүүлэх замаар бие биенийхээ дутууг нөхөж байгаа ч гэж хэлж болно.

Шашныг энэ өнцгөөс нь харах юм бол хүнийг амар амгаланд чиглүүлэгч нигүүлсэнгүй хайр гэсэн утгаараа бүгд ижил гэж хэлж болно. Улмаар шашны тэрхүү нигүүлсэнгүй хайрын үр нөлөөгөөр бид өөрсдөө ч сэтгэлийн гүнд байнга байж байдаг “Бусдыг харилцан энэрч хайрлаж, нигүүлсэх сэтгэл”-ээ ил гаргаж, түүнийгээ бодит болгохоос нааш сэтгэл үл амарна – Бурханы үйлээр бол энэ нь Бодисатвагийн зам мөр юм.

Бид өөрсдийн болон бусдын ялгааг олж харж, бусдад эелдэг хандаж чадахгүй байх үе бий. Тийм үедээ гадагшаа чиглээд байгаа нүдээ өөрийн сэтгэлийн гүн рүүгээ чиглүүлээд нэг үзвэл ялгаагаа хүлээн зөвшөөрхөд хялбар болох болно.

Би олон улсын хурлуудад оролцохдоо өөр саналтай хүнтэй учрахаараа “Надаас өөр саналтай байгаа нь гайхалтай” гэж боддог. Тэгээд тэрхүү ялгаатай, өөр байгаа зүйлээр нь дамжуулан өөртөө хараахан мэдэхгүй зүйл хичнээн их байгаагаа мэдэж авдаг.

Зөвхөн өөрийнхөө саналыг өндөр дуугаар онцолж, ялгааг бай болгон маргахаас илүү ялгаагаа хүлээн зөвшөөрч, эвлэрэн, тэрхүү найрсаг харилцааг тогтоосондоо баярлах нь аз жаргал биш гэж үү.

Цагаан Лянхуа Судрын “Эмийн ургамалаар үлгэрлэн зүйрлэхүй” бүлэгт “Түүнчлэн Ирсэний айлдах ном бол нэг төрөл нь нэг амттай” гэсэн байдаг ба шашнуудын ижил зорилгыг, хүн нэг бүрийн цээжний гүн дэх нигүүлсэнгүй сэтгэлтэй нийлүүлэн бодох юм бол энэ сансар огторгуйн хөлгийн зорчигч бүгд амар амгалан ба аз жаргалыг олж чадна гэсэн амлалтыг авсан гэсэн утгаараа “Сансар огторгуйн жинхэнэ үнэний төрх бүрийн амт болгон нь ондоо” гэж хэлж болно. Бидэнд түүнийг бодит ертөнц дээр батлах үүрэг бий.

«Косей»2019 оны 9 дугаар сарын дугаар



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Номын багш хэмээх 10 дугаар бүлэг (Эхний хагас)



Таван төрлийн номын багш

Бурханы номд суралцана гэж юуг хийхийг хэлэх вэ ...

Нэгдүгээрт, сургаалыг хүлээн авах шийдвэрийг гаргаж, тэр шийдвэрээ ул суурьтай үргэлжлүүлэх (Өөрийн болгох).

Хоёрдугаарт, сургаалыг дахин давтан суралцах (Унших).

Гуравдугаарт, түүнийг цээжээрээ дуудаж чаддаг болтлоо зүрх сэтгэлдээ суулгах (Цээжлэх).

Дөрөвдүгээрт, бусдын сайн сайхны төлөө түгэн тайлбарлаж өгөх (Түгэн дэлгэрүүлэх).

Тавдугаарт тэрхүү сургаалыг хорвоо ертөнцөөр түгээхийн төлөө төрөл бүрийн аргаар зүтгэх (Хуулан бичих).

Энэхүү Хүлээн авах, Унших, Цээжлэх, Түгэн дэлгэрүүлэх, Хуулан бичих гэсэн таван зүйлийг “Номын багшийн таван үйл” гэх ба Цагаан Лянхуа Судрын сургаалыг тахин шүтэгчийн зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай таван үйл юм. Эдгээрийн дотроос нэг нь л дутахад жинхэнэ Цагаан Лянхуа Сударыг шүтэгч гэж хэлэх боломжгүй юм.



номыг номлосон хүнийг бол өгүүлэх юун.”хэмээн дурдсан байдаг. Үүнийг уг бүлгийн хамгийн гол санаа гэж хэлж болно.

Хувцас, суудал, өрөө хэмээх гурван хэмжүүр

Тэгвэл сэтгэл санаагаа хэрхэн удирдан чиглүүлж, сургаал түгээх тэрхүү бүтээлч үйлийг хийвэл зохих вэ... Түүнийг дараах “Хувцас, суудал, өрөө хэмээх гурван хэмжүүр”-т тодорхой өгүүлсэн. Энэ бол уг бүлгийн удаах гол санаа билээ. Хэмжүүр гэдэг нь ёс зүйн хэмжүүр ба зөв зам гэсэн утгатай.

Эх хувилбарыг тэр чигээр нь илэрхийлбэл “Язгууртны хөвгүүд ба язгууртны охид бээр Түүнчлэн Ирсэнийг нөгчсөний хойно Чуулганы дөрвөн нөхдийн тулд энэхүү Цагаан Лянхуа Судрыг номлосугай хэмээх ахул . Бүх сайн эрс ба эмс Түүнчлэн Ирсэний хэрхэн номловоос зохих буй.Эдгээр язгууртны хөвгүүд ба язгууртны охид Түүнчлэн Ирсэний өрөөнд орж,

Түүнчлэн Ирсэний элч

Энэхүү таван үйлийн дотроос “Бусдын сайн сайхны төлөө тайлбарлах”, “Сургаалыг хорвоо ертөнцөд түгээх” гэсэн бүтээлч үйлийг онцгойлон дурдаж, эс гүйцэлдүүлбээс хүний нийгэм аврагдах боломжгүй болохыг ухуулан таниулах нь Цагаан Лянхуа Судрын том онцлог ба энэ бүлэгт ч гэсэн “Миний нөгчсөний хойно Нэг ч болов хүний сайн сайхны төлөө Цагаан Лянхуа Судрын нэг мөрийг ч болов номлосон гэе. Гарцаагүй мэдвээс зохино. Тэр хүн бол даруй Түүнчлэн Ирсэний элч болно. Түүнчлэн Ирсэний зардас болж Түүнчлэн Ирсэний үйл хэргийг гүйцэтгэх болно. Олон хүний төлөө



Түүнчлэн Ирсэний хувцасыг өмсөж, Түүнчлэн Ирсэний суудалд суугаад Чуулганы дөрвөн нөхдийн тусын тулд энэхүү судрыг өргөн дэлгэр номловоос зохино.” гэсэн байдаг.

Энэхүү “Түүнчлэн Ирсэний өрөөнд орох”, “Түүнчлэн Ирсэний хувцасыг өмсөх”, ”Түүнчлэн Ирсэний суудалд суух” гэдэг нь сургаалынхаа үүднээс ч эрхэм чухал төдийгүй, үнэхээр талархан хүлээж авбал зохилтой үг болохыг сайтар мэдрэх хэрэгтэй. Үнэхээр их талархмаар.

Дээрх гурван хэмжүүрийн утгыг энд “Түүнчлэн Ирсэний өрөө гэдэг нь хамаг амьтны дундах агуу их нигүүлсэнгүй сэтгэл болой. Түүнчлэн Ирсэний хувцас гэдэг нь зөөлөн сэтгэл ба хүлцэнгүй тэвчээр болой. Түүнчлэн Ирсэний суудал гэдэг нь хамаг ном хоосон чанартай болой.” хэмээн товч бөгөөд тодорхой тайлбарласан. Өөрөөр хэлбэл “Нигүүлслийн сэтгэл”, “Тайван зөөлөн, хүлцэнгүй байдал” ба ”Хоосон чанарт гэгээрсэн билиг оюун” гэсэн гурван үзэл баримтлалаар сургаалыг айлдах ёстой гэж сургасан.

Эдгээрийн дотроос “Нигүүлслийн сэтгэл” ба “Тайван зөөлөн, хүлцэнгүй байдал”-ын тухай тайлбарлах шаардлага байхгүй болов уу.

Хамгийн сүүлийн “Хоосон чанар”-ыг хэрхэн хүлээн авбал болох вэ... Энд дахин тайлбарлъя. “Хоосон чанар”-ыг тайлбарлах хоёр арга зам бий. Нэгдүгээрт, бүх юмс үзэгдэл бол “түр зуурын шинжтэй” болохыг нь олж харах явдал юм. Мэдээж зөв арга боловч зөвхөн үүнд тулгуурлалаа гээд бусдыг бүх хүнийг амжилттай аврах сайн арга болохгүй.

Тиймээс бид тэрхүү “Хоосон”-ыг илүү бүтээлчээр бодох шаардлагатай. Бүх эд юмсыг “Хоосон” гэдэг нь энэ ертөнц юу ч үгүй гэсэн үг биш. Үйлийн үрийн нөхцөл шалтгаанаар гарцаагүй оршин буй. Гагцхүү үүрд үл өөрчлөгдөх, хатуу тогтсон зүйл гэж нэгээхэн ч үгүй гэсэн үг. Тиймээс сайн сайхныг хүсвээс сайн үр шалтгаан, сайн үйл бүтэх болно.

Ингэхэд “Хязгааргүй утгасын судрын ном номлохуйг өгүүлэх бүлэг”-т “Үнэнхүү хамаг ном болбоос өөрийн мөн чанараараа өнгөрсөн, одоо, ирээдүйд бэлгэ чанар хоосон бөгөөд их



бус, өчүүхэн бус, төрөхгүй, түрдэхгүй, суухгүй, явахгүй, давшихгүй, харихгүй бөгөөд тэрчлэн огт оргүй мэт хоёр ном байхгүй хэмээн үзвээс зохино. Тийм атал хамаг амьтан энэ бол энд, энэ бол тэнд үүнийг олж, үүнийг алдав гэхчлэн эндүү ташаа бодож, нүгэлт сэтгэлийг үүсгэн, муу үйлийг хийж, сансрын зургаан төрөл дотор орчиж баймуй.” гэсэнчлэн бүх юмс үзэгдэл угаас тогтсон ялгаагүйгээр, эрх тэгш агуу зохицол дунд оршиж байдаг. Өөрөөр хэлбэл юмс үзэгдэлд сайн муу гэж байхгүй. Харин эгэл жирийн хүн тэгж хардаггүй бөгөөд юмсыг ялгавартайгаар хардаг учраас муу санаа сэтгэлийг өдөөн, түүнээсээ болж зовдог. Өөрөөр хэлбэл юмсыг ялгаатайгаар харж, зовоод байгаа нь эгэл жирийн хүний алдаа бөгөөд уг нь бол бүх юмс үзэгдэл ялгаагүй, эрх тэгш энх тайван оршин тогтнож байдаг. Өөр үгээр илэрхийлбэл бүх юмс байх ёстой учраас л оршин тогтнож байдаг. Бидний хүн төрөлхтөн ч гэсэн адил билээ.

Бид энэ ертөнцөд амьдрах хэрэгцээ шаардлага байгаа учраас л ийм хэлбэрээр төрөн бий болсон. Тэр үүднээсээ хүн төрөлхтөн хэмээн амьдарч байгаагийн үнэ цэнэ, бие биеийнхээ тус дэмэнд амьдарч байгаагийнхаа ач



бусдад номлол айлдах нь “Түүнчлэн Ирсэний суудалд суух” өөрөөр хэлбэл тогтсон “Хоосон чанар”-ыг гэгээрэх үндэс болно хэмээн сургадаг.

Энэхүү гурван хэмжүүрийг нэгтгэн хэлбэл “Бусдад Цагаан Лянхуа Судрыг айлдахдаа агуу их нигүүлсэнгүй сэтгэлээр, хоосон чанарын жинхэнэ гэгээрлийг үндсээ болгон, асуудалд уян хатан, зөөлнөөр энэ ертөнцийн ямар ч магтаал, доог тохуунд нугарашгүйгээр сэтгэлийнхээ угаас номлох ёстой.” гэсэн сургаал юм. Үүнийг л “Номын багш хэмээх бүлэг”-ийн гол цөм нь гэж болно.

тусыг гүн гүнзгийгээр мэдрэхгүй байхын аргагүй. Мөн бусад хүмүүс ч гэсэн адилхан энэ ертөнцөд амьдрах хэрэг, бүтээх үүрэг байгаа учраас л мэндэлсэн хэрэг. Ингээд бодохоор бусдын оршин тогтнож буй үнэ цэнийг ч гэсэн хүлээн зөвшөөрөхгүй байхын аргагүй.

“Хоосон чанар” гэдгийг ингэж хүлээж авах юм бол амьдрахын үнэ цэнэ, баяр баяслыг гүн гүнзгий мэдэрч чадна. Бүгд адил хувь заяанд төрсөн ах дүүс гэсэн дотно сэтгэл бодитойгоор оргилон гарч ирэх болно. Тэгж байж гэмээнэ

Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X. 104-109

Ялгааг хүлээн зөвшөөрч, хоорондоо эвтэй байх

Өнгөрсөн 7-р сард Америкт сургаал түгсний 60 жилийн ой тохиож, 300 гаруй номын андууд маань сургаалтай учирсны баяр хөөрөө хуваалцаж, мөн хойшдын чиг шугамаа дахин тодорхойлсон арга хэмжээ зохион байгуулагдлаа.

Мөн энэ үеэр Бразил нийгэмлэгийн үүсгэн байгуулагдсны 48 жилийн ойн арга хэмжээ болж, миний бие аль алинд нь оролцох завшаан тохиов.


АНУ-д ч тэр, Бразилд ч тэр би ижил зүйлийг мэдрэв. Тэр нь хүүхдүүд болон залуучууд, өөр өөрийн онцлог, давтагдашгүй чанараа ил гарган, хоорондоо харилцаж байгаа байдал. Тэдний байр байдал хүнд тус болох юмсан, бусдыг баярлуулах юмсан гэсэн сэтгэлээр дүүрэн байлаа.

Энэ сарын Нивано ерөнхийлөгчийн сургаалд гарч байгаа хүн бүрийн дотор оршиж байдаг “бусдыг хайрлах, энэрэх сэтгэл”-ээ аль хэдийн олж нээгээд, ил гаргасан бодисадва нар байна даа гэж бодогдсон.


Энэ сард Германд “10 дахь удаагийн дэлхийн шашинтнуудын энх тайвны хурал” зохион байгуудагдах бөгөөд дэлхийн энх тайвны төлөө шашинтнууд юу хийж чадах, хэрхэн хувь нэмрээ оруулж чадах вэ гэсэн сэдвээр ярилцах болно.

Бид ч гэсэн өдөр тутамдаа бие биенийхээ ялгааг хүлээн зөвшөөрч, энх тайван нийгэм, амьдралыг цогцлоохын төлөө хичээх хэрэгтэй.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: info@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 POBox 33636, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 FAX: 1-650-359-6437
 Email: info@rksf.org URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-262-4437
 Email: info@rkina.org URL: <http://www.rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692042, San Antonio, TX 78269, USA
 TEL: 1-210-561-7991 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 FAX: 1-253-945-0261
 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059, West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL/FAX: 880-31-626575

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Patiya

China Clinic, Patiya Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni,

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

2F Ikh Mandal building, Khurenbulag bag, Bayan-Undur sum,
Orkhon province, Mongolia

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Paris

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>